



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар сарын 30 өдөр

Дугаар 22/001

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт,
Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон
Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн
дээр 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг
хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар сарын 30 өдөр

Дугаар 22/002

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Айтүүлс” ХК-ийн 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Ердийн гишүүд:

1. Г.Хатанболд
2. А.Баттамир
3. Н.Улаанхүү
4. Б.Амгаланбаатар
5. Д.Даваа
6. Б.Тамир

Хараат бус гишүүд:

1. Г.Гантуяа
2. Н.Жавхлан
3. З.Саранчимэг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар сарын 30 өдөр

Дугаар 22/003

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн цалин,
урамшууллын төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт,
“Айтүүлс” ХК-ийн 2022 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны болон гишүүдийн цалин урамшууллыг **47,107,360** /дөчин долоон сая нэг зуун долоон мянга гурван зуун жар/ төгрөгөөр баталсугай.
2. Төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД